

“ХӨВСГӨЛ” ХК

2024 оны 04 сарын 30

№ 24/03

Улаанбаатар хот

“ХӨВСГӨЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Компанийн өрийг хувьцаагаар солихоор шийдвэрлэж,
хаалттай хүрээнд нэмж энгийн хувьцаа гаргах

Компанийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3 дахь хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.3, 62.1.16 дахь заалт, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг, 2024 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 24/01 тоот Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн зарласан энгийн хувьцаанаас нэг бүр нь 126.17 (нэг зуун хорин зургаан төгрөг арван долоон мөнгө) төгрөгийн ханшаар тооцон 86,655,338 (наян зургаан сая зургаан зуун тавин таван мянга гурван зуун гучин найм) ширхэг энгийн хувьцааг Ард Санхүүгийн Нэгдэл ХК болон Компани нарын хооронд байгуулсан Авлагын гэрээний холбогдох заалтын дагуу 10,933,304,000 (арван тэрбум есөн зуун гучин гурван сая гурван зуун дөрвөн мянга) төгрөгийн өглөгийг энгийн хувьцаанд хөрвүүлэхээр шийдвэрлэж, Компанийн өрийг энгийн хувьцаанд хөрвүүлэх төслийг Хавсралтаар баталсугай.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, шаардлагатай бусад арга хэмжээг авч ажиллах, холбогдох баримт бичигт Компанийг төлөөлж гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захиралд олгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.УЯНГА